

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23-Р СУРГУУЛИЙН

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ Б.ГЭРЭЛИЙН 2018-2019 ОНЫ

ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТӨЛӨВШИЛ: Оролцоо

- Энэ хичээлийн жилд анх сургуульд орж байгаа 6 настангуудыг хүлээн авч сургуулийн орчинд дасан зохицох чадвар эзэмших,бие даан болон хамтаар суралцах арга барил эзэмшүүлэхийг зорин ажиллалаа. Иймээс тэдний онцлогт нийцүүлэн сургалт болон сургалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулсаар ирлээ.
- Сургуулийн орчинд ба сургалтын явцад биеэ хэрхэн зөв авч явах тал дээр тогтмол анхааран ажиллаж ирлээ. Мөн сургууль болон анги танхимд баримтлах дэгийг хэрэгжүүлж эхэллээ.

Дадал хэвшил

- 1-р ангийн сурагчид маань дүрэмт хувцсаа болон биеийн тамирын хувцсыг бүрэн,цэвэр өмсөж хэвшсэн.
- Сурагчид маань хичээл орох болон тарахад тогтмол жагсаж бусад ангиудад үлгэрлэх хэмжээнд хүртэл жагсаалч байдлаа хэвшил болгож чадлаа.
- Гадуур хувцсаа өөрөө өмсөж,тайлан зориулалтын уутанд хийж шүүгээндээ хийж хэвшлээ.
- Сурагчид маань сургуулиас тарааж өгсөн сурах бичиг болон тарааж өгөх материал зэргийг нямбай хэрэглэн хичээлийн жилийн эцэст тоо ёсоор нь номын сандаа буцаан өглөө.Зарим элэгдэж урагдсан номыг эцэг,эхийн тусламжтайгаар эмчилсэн. Энэ нь аливаад ариг гамтай хэрэглэх нямбай ажилд сургасан ажил болсон.
- Үдийн цай хөтөлбөрт тогтмол хамрагдсаар ирсэн.Энэ үеэр хувийн ариун цэвэр сахиж хэвшлээ.

Зан чанар

- Санал бодлоо бусдад илэрхийлэх,бусдыг хүндэтгэн харилцах,зөрчил маргааныг эв зүйгээр шийдвэрлэх тал дээр дэвшил гарсан.
- Сургуулийн багш ,ажилтан ,өөрөөсөө ахмад хүмүүстэй мэндлэх хүндлэх зан чанарыг хүүхдүүд маань хангалттай сайн эзэмшиж байна.

- Монголын уламжлалт зан заншил,соёлоос суралцан эх түүхээ бахархан дээдлэх эерэг зан чанар төлөвшиж эхэллээ.
- Эх дэлхий байгальтайгаа элгэмсэг сайхан харилцах ёстойг ойлгон хэрэгжүүлж эхэлсэн.
- Аливааг сонирхон судалж судлан мэдэх хүсэл эрмэлзэлтэй болсон.
- Шинэ орчинд дасан зохицох чадварт суралцаж эхэлсэн.

СУРАГЧ НЭГ БҮРИЙН СУРЛАГЫН АМЖИЛТ :

Гарсан ахиц:

- Хичээлийн жилийн эхэнд гарааны оношилгоо авч сурагчдыг оношилсон.Үүнд:Үзэг, харандаа барьж зурж бичих чадвар сул сурагчид байсан бол одоогийн байдлаар ангийн бүх сурагчид бүх үсгээ,үеэ нүдлэн холбон уншиж сайхан бичиж бодож сурсан бахархам амжилтаар хичээлийн жилээ үдэж байна.
- Монгол хэлний хичээлээр сурагчид маань бүх үсэг үеэ нүдлэн амжилттай уншиж бичиж сурлаа.
- Математик хичээл дээр 100 дотор нэмэж хасаж сурлаа.Математик сонины нэрэмжит намрын сорилго олимпиадад оролцлоо.Үүнээс:Сурагч: Батбаяр,Мишээл,Энэрэл,Оюутдалай,Маршал нар амжилттай оролцон дээгүүр үнэлгээтэй шалгагдсан.
- Хүн орчин хичээлээр байгаль орчноо хайрлахын ач холбогдлыг ойлгон хог хайхгүй байх усыг гамгүй хэрэглэхгүй байх зэрэг наад захын хэрэглээний соёлд суралцлаа.
- Дүрслэх урлагийн хичээлээр будах технологи гэх мэт олон зүйлд суралцан хэрэглээ болгож сурлаа.

АВЬЯАС ЧАДВАРЫГ НЭЭСЭН БАЙДАЛ:

- Энэ хичээлийн жилд ангийн нийт сурагчдыг зөв алдаагүй,цэвэр сайхан бичих чадварт сургахыг зорин ажилласан нь биелэлээ олсон.
- Сурагчдын бүтээлийн үзэсгэлэн тогтмол гаргаж байсан хүүхдийн авьяасыг хөгжүүлэхэд нөлөөлөхүйц ажил болсон.
- Ангийн сурагчдын эцэг эхээс авьяасын судалгаа аван нэгтгэн дүгнэлээ.
- Ангийн сурагчдын 20% нь буюу 12 сурагч дугуйлан секцэнд хамрагдсан байна.

АВЬЯАСЫГ ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ:

- Ангийн нийт сурагчид 20 гаран шинэ шүлэг цээжлэн уран тод унших дасгал хийж шүлгийн утгыг ярилцаж гар зургаар илэрхийлж байсан хүүхдийн сэтгэлгээг хөгжүүлэх сайн дасгал болж байлаа.
- Сургуулийн уламжлалт ажлуудын нэг болох урлаг наадам “Авьяаслаг 23” манай ангийн сурагч н.Ундрамын уран уншлагын үзүүлбэрээр нээгдсэн билээ.
- Ангийн сурагчдын дунд “Цэвэр сайхан бичигтэн болцгооё “ цэвэр бичгийн уралдаан зохион байгуулан үзэсгэлэн гаргав.
- 1в ангийн сурагчдын дунд шатар болон даамны аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж сурагч н.Ихбилигт аварга болж дүүргийн тэмцээнд амжилттай оролцов
- 1в ангийн сурагчдын бүтээлээр нь ангидаа тогтмол үзэсгэлэн гаргаж байсан эерэг нөлөө үзүүлж байлаа.Хүүхдийг бүтээлээр тал бүрээр хөгжүүлж болох нь харагдаж байлаа.
- Сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд олон талт ажил зохион байгуулж байснаар тэдний бүх талын авьяас чадвар хөгжсөөр ирлээ.

Сургууль олон нийтийн ажилд оролцсон байдал

№	Хугацаа	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулсан газар	Үүрэг оролцсон байдал
1	Хичээлийн жилийн турш	-Багш нарын зөвлөгөөн -Цаг үеийн шуурхай хурал зөвлөгөөн	23-р сургууль	-Багш нарын зөвлөгөөний хурлыг тасалж үзээгүйг цохон тэмдэглэе. -Цаг үеийн хуралд сууж мэдээлэл авч ажилдаа хэрэгжүүлж ирэв.
2	9 сар	Багш нарын буухиа тэмцээн	23-р сургууль	Багаараа 3-р байр
3	Намар Хавар	Мод тарих өдөр	23-р сургууль	-Намар сургууль орчны ногоон байгууламжийг цэвэрлэсэн -Хавар цэвэрлэгээ хийж мод тарьсан.
4	10,11 сар	Дадлага удирдах үйл ажиллагаа	23-р сургууль	2 оюутан 1 в ангид дадлага хийв,МУБИС-ийн БС 4-р курс

				н.Мягмарсүрэн,н.Одончимэ г
5	10,11 сар	Мүүдл сургалт	23-р сургууль	Мүүдль системийг ашиглах аргад суралцсан
6	Хичээли йн жилийн турш	Цэнэглэх цаг	23-р сургууль	Цэнэглэх цагт сууснаар төрөл бүрийн мэдлэг олж авсан.
7	Хичээли йн жилийн турш	ЗАН болон секцийн хурал	23-р сургууль	Цаг үеийн байдлын талаарх мэдээллийг тогтмол авдаг
8	1-р сард	Мүүдл шалгалт	23-р сургууль	Мүүдл системийг хэрхэн ашиглаж сурснаа шалгуулав. 98%үнэлгээ авсан
9	Эцэг эхийн нээлттэй хаалга		23-р сургууль	1-р ангиудын нээлттэйш хаалганы өдөр амжилттай зохиогдов.

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ:

Эцэг эхийн сэтгэл ханамж:

- Эцэг эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд улирал тутам эцэг эхийн хурал зохион байгуулж сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгсөөр ирлээ.
- Хичээлийн жилийн эхэнд багш,сурагч,эцэг эхийн дунд гурвалсан гэрээ байгуулж хичээлийн жилийн эцэст гэрээгээ дүгнэлээ.
- Үдийн цайны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор амталгаат өдөрлөгт эцэг эхчүүдийг хамрууллаа.
- Эцэг эхээ дөрвөн багуудад хуваан улирал бүр эцэг эхийн оролцоотой ажлуудыг төлөвлөн төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгууллаа.
- Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөр амжилттай зохион байгууллаа.
- Хичээлийн жилийн төгсгөлд эрдмийн баяраа “Бид хамтдаа” нэрийн доор зохион байгуулан хүүхдүүд маань сурсан мэдсэнээ эцэг,эх болон сургууль багш нартаа амжилттай тайлагналаа.

Сурагчийн сэтгэл ханамж:

- Ангийн сурагчдын бүтээлээр ангидаа бүтээлийн үзэсгэлэн тогтмол гарган ажилласан.
- Ангидаа цэвэр сайхан бичигтэнг шалгаруулав.
- Ангийн аварга шатарчин,даамчин шалгарууллаа.
- Сурагч н.Батбаяр сургуулийн 1-р ангийн сурагчдын аварга болов.
- Сурагч н.Мишээл,н.Оюутдалай математикийн олимпиадад амжилттай оролцож дараагийн шатны уралдаанд орох болсон байдаг.
- Сурагч Б.Мишээл сурлагаараа хамт олноо манлайлан сургуулиас шагнал авсан.
- Сурагч С.Маршал Монте Роза сургуулийн нэрэмжит олимпиадад амжилт гаргасан.

ЭРҮҮЛ МЭНД:

- Эрүүл амьдрах наад захын зөв дадал бол гараа зөв угаах явдал юм.Гар угаах өдрийг тохиолдуулан “Гараа хэрхэн зөв угаах “ талаар сургалт зохион байгуулав
- Амны хөндийн ариун цэврийн талаарх сургалтыг зохион байгуулав.
- Сургуулийн эмчтэй хамтран ангийн сурагчдыг 100% өндөр жингийн үзлэгт хамрууллаа.
- Сурагч А.Номун товлотт вакцинд хамрагдлаа.
- Эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөн ангиараа өдөр бүр хөгжмийн аянд дасгал хийж хэвшлээ.

ЭРҮҮЛ ХАРИЛЦАА:

- Өөрөөсөө ахмад хүмүүс болон багш ,ажилчидтай түрүүлэн мэнд мэдэх тал дээр дадал болж эхэллээ.
- Найз нөхөдтэйгээ эелдэг найрсаг хандан бусдын юмыг зөвшөөрөлгүй авах хамаагүй биед нь гар хүрэхгүй байх гэх мэт наад захын соёлд суралцаж эхэллээ.
- Талархал болон уучлалтын үгийн оновчтой үед хэрэглэж хэвшүүлэхийг зорин ажиллалаа.Үүний үр дүнд үдийн цайгаар үйлчилдэг гал тогооны эгч нартаа талархлын үгийг хэлж хэвшиж байна.

ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН:

- Сурагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хичээлийн улирлын амралт болгоноор хүүхдийг эцэг эхийн хяналтанд хүлээлгэн өгөн эцэг,эхээр гарын үсэг зуруулан баталгаажуулж байлаа.
- Ангийн сурагчдыг Гараас гарт хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байна.
- Гараас гарт хөтөлбөрийг танилцуулах үйл ажиллагааны хүрээнд эцэг эхийн хурал дээр мэргэжлийн байгууллагын хүн урин яриа таниулга хийлгэлээ.

- Эцэг эхийн анхдугаар зөвлөгөөн дээр 1в ангийн төлөөлөл лекц уншсан нь үр дүнтэй ажил боллоо.
- Ангийн сурагчдыг 100% цүнхний цацруулагчтай болгосон
- Сургуулийн зүгээс өгч байгаа анхааруулга сануулгыг тогтмол сурагчид болон эцэг эхэд танилцуулж гарын үсгээр баталгаажуулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ

Б.ГЭРЭЛ